

6. Есүс Сүйт Бүсгүйгээ Гэмшил рүү дуудаж байна.

Есдүгээр сарын 1, 2014 _ Эгч Кларид ирсэн Есүсийн үгс

Эзэн Өөрийн Сүйт бүсгүйгээ буюу Сүйт бүсгүй болох боломжтой нэгнийг гэмшил рүү дуудаж байна. Тэд Rapture (дээш өргөгдөн диваажинд Есүстэй хамт байх)-д бэлэн биш байгаа ба Есүс тэднийг бэлэн болохыг хүлээж байна. Би үүний өмнөх сургалтаараа яагаад Америкд эдийн засгийн уналт болсон шалтгааны тухай заасан. Энэ нь энэ ертөнцийн элдэв юмсаас тэдний сэтгэл санааг Өөртөө татаж, Сүйт бүсгүйгээ буцаан авахын тулд Эзэн үүнийг зөвшөөрсөн юм.

Таны мэдэж байгаачлан энэ улсад маш олон чинээлэг Христэд итгэгчид байдаг. Хүмүүс хэн нэгэн Христэд итгэгчийн амьдрал сайнгүй бол, тэр хүнд эд баялагтай болох итгэл байхгүй байна гэж ярилцдаг. Энэ бол үнэнээс маш холуур зүйл юм, яагаад гэвэл Шинэ Гэрээнд эд баялаг, мөнгө хоёр нь Есүсийн санаа бодолд хамгийн сүүлд нь байсан. Хуучин Гэрээнд, энэ нь заримдаа Бурханы таалалын шинж тэмдэг байсан, харин Шинэ Гэрээнд Есүс тодорхой түвшинг тогтоосон байдаг.

Есүс хаан юм уу хан хүү болж төрөөгүй бөгөөд тэдэн шиг амьдрахыг ч сонгоогүй. Тэр энгийн даруу амьдралыг, ертөнцийн юмсаас холуур байх тийм амьдралыг л сонгосон.

Тиймээс, Тэр түүнийг дуурайх Сүйт бүсгүйг хайж байна.

Тэгээд, Есүс надад энэ мэдээг өгсөн :

" Гоё ганган хүмүүс бол Миний Сүйт бүсгүй биш. Би чин сэтгэлээсээ нүгэлээ наминчлан өөрийгөө өчүүхэн болгосон нэгнийг хайж байна. Би Намайг дуурайгсадыг хайж байна. Миний Сүйт бүсгүй яг л ийм байна. Би өчүүхэн дорд бүхэнд агуу итгэлийг өгөхийг хүсч байна. Тэд бол Миний Үзэсгэлэнтүүд. Тэд нар л энэ дэлхий дээр Намайг хамгийн их дуурайгсад.

Намайг ингэж хэлж байгаад уучлаарай, гэхдээ Вавилоны гоёмсог хатагтай нарыг, та нарынхаар бол Холивуудын оддыг дуурайсан Миний итгэгчид их олон байна. "

"Гэвч энэ бол Диваажин болохоос Холивууд биш гэж Миний хэлдгээс та нар залхаж байгааг Би мэдэж байна. Энд ямар ч юмс Дэлхий дээрх та нарын агуу гэгддэг юмстай харьцуулашгүй."

Би Өөрийн Сүйт бүсгүйг, Миний Хүмүүсийг гэмшил рүү урин дуудаж байна. Би ямар ч утгаар Миний Сүйт бүсгүй бол энэ дэлхийн дээрх сайн хүмүүс гэх гээгүй, харин тэд амьдралдаа Намайг дуурайн хавчигдан гадуурхагдаж, бусдын доог тохуу болж тэдэнд үл тоогддог.

" Тэдний зүрх сэтгэл бусдын хахир хатуу басамжлалаас болж шархладаг. Миний зүрх сэтгэл тийм хүмүүс рүү ойртдог. Тэднийг гаднаас нь хараад хэн ч ялгахгүй ч, тэд тэдгээр зовлон шаналалыг нэр төртэйгөөр тээж явдаг. Тэд бол Миний сонгосон хүмүүс ба мөн хамгийн өчүүхэн гэгддэг ядарч зүдэрсэн хүмүүс ч орно. "

" Би үүнийг дахин дахин хэлж байна, гэвч энэ нь хамгийн хамаатай, хамгийн чухал нь. "

" Би сайхан хувцасласан христүүдийг биш, харин Сүйт бүсгүй болж болмоор хүмүүсийг хайж байгааг та нар мэдээсэй гэж хүсч байна. Үнэндээ, хамгийн өчүүхэн нэгнийг хайж байна. Миний титэмийг өмсч чадахгүй гэж бодож байгаа тэдгээр хүмүүсийг Над руу авчир. Үнэхээр тэд бол Минийх гэдгийг тэдэнд ихэд итгэлтэйгээр ятган итгүүл. Тэд бол Миний Сүйт бүсгүй. Тэд бол Миний Сонгосон хүмүүс. Мөн тэдгээрийг тойрон хүрээлж буй хүмүүс бүгд Надад хамгийн их чухал.

" Тэд үнэхээр анхны сонгогдогсодтой адил хөлсөөр төлөгдөх ба тэд өчүүхэн дорд болон хүсээгүй нэгний урд нь байх болно. "

Энэ бол Эзэний яг одоо Сүйт бүсгүйдээ болон Сүмдээ хэлэх зурвас юм.